



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 5 сарын 7 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Журамд нэмэлт өөрчлөлт  
оруулах тухай

Төвсийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 17 дугаар тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-д дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

**1. Гурав. Төсвийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх**

3.32 Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийн хөрөнгөөр хийгдэх барилга байгууламжийн угсралт, их засварын ажил, худалдан авах тоног төхөөрөмж (цаашид төсвийн хөрөнгө оруулалтын ажил гэх)-ийн ажлын эрхийг Аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлж болно.

3.33 Аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар эрх шилжиж ирсэн төсвийн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхдээ "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ыг мөрдлөгө болгоно.

3.34 Төсвийн ерөнхийлөн захирагч эрх нь шилжсэн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, ажлын явцыг газар дээр нь хянан шалгаж, мэргэжлийн хяналтыг байнга тавьж ажиллана.

3.35 Эрх нь шилжсэн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг Аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хянаж, баталгаажуулан санхүүжилт хүссэн материалыг Аймаг, Нийслэлийн Засаг даргын гарын үсэг бүхий албан тоотоор Сангийн яам /Төсвийн асуудал хариуцсан нэгж/-д хүргүүлнэ.

3.36 Сангийн яамны Төсвийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3.5 дугаар заалтыг үндэслэн санхүүжилтийг Аймаг, Нийслэлийн Төрийн сангийн дансанд шилжүүлнэ.

3.37 Захиалагчийн төрийн сан дахь хөрөнгө оруулалтын төсвийн данс банкны жилийн эцсийн тайлангаар үлдэгдэлгүй байх бөгөөд энэ заалт барьцаа хөрөнгөнд хамаарахгүй.

000217

## 2. Тав. Тайлагнах

5.7 Аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар эрх шилжсэн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын тайланг сар бүр "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын тавдугаар хэвсрэлтээр батлагдсан маягтын дагуу гаргаж, сар бүрийн дараа сарын 5-ны дотор Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

3. Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлыг тайлан бүртгэлд тусган, үндсэн хөрөнгөд бүртгэнэ" гэж нэмсүгэй.

4. Энэ журмын 3.20, 3.21, 3.22, 5.2 дугаар заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

Хоёр. Энэ журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-т, Төрийн сангийн газар /Ч.Тавинжил/-т, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Батцэцэг/-т тус тус даалгасугай.

Гурав. Энэ тушаал батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

САЙД



Ч.УЛААН